МБҮА
МОНГОЛЫН БАРИЛГЫН ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ
SINCE 2009

Зөв зүгт
Манлайлна

Барилгаидаараа Бахархья

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

02-Р САР

2026

International Federation of Asian and Western Pacific Contractors' Associations (IFAWPCA)
"Board Member"

FIDIC International of consulting engineers
"Associate Member of FIDIC"

www.mnca.mn

МБҮА

+976-7011 1515

info@mnca.mn

www.mnca.mn

Монголын Барилгын
Үндэсний Ассоциаци

РЕДАКЦИ

ХЯНАН ТОХИОСОН:
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
М.ЭНХБААТАР

НЭГТЭЛ РЕДАКТОР:
Б.ТӨВШИНБОЛОР

ОРОЛЦСОН:
АЖЛЫН АЛБА

АГУУЛГА

НИЙГМИЙН ҮНЭ ЦЭНИЙН ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО:

УДИРДЛАГЫН МАНЛЛАЙЛЫГ ХАНГАЖ, НӨЛӨӨЛЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ИДЭВХЖҮҮЛЭХ

САЛБАРЫН БОДЛОГО, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР:

ГИШҮҮНЧЛЭЛ, МРКЕТИНГ, СУРГАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР

БАРИЛГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГАА

МБҮА

МОНГОЛЫН БАРИЛГЫН ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ

SINCE 2009

Зөв зүгт Манлайлна



+ 976 7011 1515 www.mnca.mn

МБҮА

МОНГОЛЫН БАРИЛГЫН ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ

SINCE 2009

Зөв зүгт Манлайлна

21 АЙМАГТ АССОЦИАЦИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙГ байгуулж эхэллээ

АССОЦИАЦИ НЬ САЛБАР ЗӨВЛӨЛҮҮДТЭЙ ДАРААХ ЧИГЛЭЛЭЭР ХАМТРАН АЖИЛЛАНА.

- Сургалт, зөвлөгөөн
- Туршлага солилцоо
- Төслүүд, хөрөнгө оруулалт
- Шударга өрсөлдөөн, стандартын хяналт

7011 1515 info@mnca.mn

www.mnca.mn



БАЯН-ӨЛГИЙ **ХОВД** **ДАРХАН-УУЛ**

Аймгуудад САЛБАР ЗӨВЛӨЛ-ийг байгуулаад байна.

МБҮА
МОНГОЛЫН БАРИЛГЫН ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ
SINCE 2009

Монголын Барилгын Үндэсний Ассоциаци ТББ

2026 Зохион байгуулагдах томоохон арга хэмжээнүүд

Зөв зүгт Манлайлна

Арга хэмжээний нэр	Огноо	Зорилго
“Construction market-2026”	2026.04-р сар	МУ-ын эдийн засгийн нөхцөл байдал, барилга бүтээн байгуулалтын салбарт хэрхэн нөлөөлөх, барилгын зах зээлийн нөхцөл байдал, санхүүжилт хөрөнгө оруулалт, судалгаа зэрэг нэгдсэн мэдээ, мэдээллийг хүргэх.
“Барилгын салбарын Удирдах ажилтнуудад зориулсан ХАБЭА сургалт” *(Төв, Хангайн болон Зүүн бүсийн аймгуудад)*	2026.03-11 саруудад	ХАБЭА-н хууль тогтоомж, эрсдэлийн удирдлага болон байгууллагын ХАБЭА -н зохион байгуулалтын мэдлэг, чадвар олгохоос гадна барилгын үйл ажиллагаа тусгай зөвшөөрлийн хүсэлт гаргах заавар зөвлөгөөг хүргэх.
“Барилгачдаараа Бахархья-2026”	2026.01-12-р саруудад	Барилгын салбар үүсэж хөгжсөний 100 жилийн ойд зориулсан байгууллагын болон Гишүүн байгууллагуудын үйл ажиллагааг сурталчлах компанит ажил.
“Барилгын салбарын ажиллах хүчний асуудал гарц, шийдэл”	2026.05-р сар	Барилга, дэд бүтцийн салбарын ААНБ-уудын ажил олгогчдод нэн шаардлагатай ажиллах хүчний хэрэгцээ, мэргэжлийн ур чадварын түвшин, хөдөлмөрийн нөхцөл, болон дотоодод дутагдаж буй хүний нөөцийг гадаадаас оруулж ирэх боломжийг бий болгох
Барилгын үйл ажиллаагаааны тусгай зөвшөөрлийн өөрчлөлт-шинэлэлт- үр дүн *Хэлэлцүүлэг, Нээлттэй өдөрлөг*	2026.11-р сар	• Тусгай зөвшөөрөлтэй холбоотой асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар олон талын саналыг сонсож, хэлэлцэж, шийдвэр, гаргалгаа, санал хүсэлтийг авах • Салбарт үзүүлэх Ассоциацийн байр суурийг илэрхийлэх, нөлөөлөх.
“Барилгачдын нэгдсэн чуулган-2026”	2026.12-р сар	Барилгын салбар үүсэж хөгжсөний 100 жилийн ойд зориулсан байгууллагын үйл ажиллагааг сурталчлах, нэр хүндийг өсгөх
“Construction Award-2026”	2026.12-р сар	Барилгын салбарын шилдэг ААНБ-уудыг шалгаруулах, тэдгээрийг алдаршуулах

Хэвлэмэл товхимолын нэр

“МУ-ын барилгын салбар - 100” тоон эмхэтгэл	2026.04-р сар	
“Өнөөдрийг бүтээсэн 100 жил” алдаршуулах товхимол	2026.09-р сар	Салбарт үзүүлэх Ассоциацийн байр суурийг илэрхийлэх, нөлөөлөх. Гишүүдийг сэтгэл ханамжийш дээшлүүлэх.

Арга хэмжээ, товхимлыг ивээн тэтгэн, хамтран ажилласнаар:

- **2026 онд Ассоциацаас зохион байгуулагдаж буй арга хэмжээ бүрт ЛОГО-г байршуулах** / баннер, постер, станд, видео шторк, байгууллагын албан ёсны сошиал холбоосыг сошиал хуудсанд байршуулах гэх мэт/
- **Арга хэмжээнд үйл ажиллагаагааг сурталчлах, танилцуулах**
- **Эмхтгэл, товхимолд өнгөт сурталчилгааг байршуулна.**
- **Бусад**

Дэлгэрэнгүй мэдээллийг:
+(976) 8803 5708
+(976) 9102 1020

2026 САЛБАРЫН БОДЛОГО, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР



МҮХАҮТ-ЫН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ БОЛЛОО



МБҮА ТББ нь МҮХАҮТ-ын Удирдах зөвлөлийн гишүүн бөгөөд 2026.02.27-ны өдөр танхим Удирдах зөвлөлийн ээлжит хурлаа хийлээ. Хурлаар 2025 оны үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн танилцуулга, Хяналтын зөвлөлийн танилцуулгыг хийж улмаар 2026 оны үйл ажиллагааны үндсэн чиглэлээ танилцуулж энэ оныг "Бодлогын өмгөөллийн жил" болгон зарлахаар тогтлоо.


МОҮҮАрбитрт хэрэг хянан шийдвэрлэсэн арбиртч, нарийн бичгийн дарга, илтгэгч нарт мөнгөн урамшуулал олгох журмын шинэчилсэн найруулгын төслийг танилцуулж, Арбитрын үндсэн зардал болон нэмэлт зардлын хэмжээ тооцох журамд оруулах нэмэлт өөрчлөлтийг танилцуулан батлууллаа. Мөн Монголын олон улсын Арбитрын Арбитрчдын нэрсийн шинэчилсэн жагсаалтыг танилцууллаа.

Уг хуралд танхимын Удирдах зөвлөлийн гишүүн, МБҮА ТББ-ын Ерөнхийлөгч Н.Баярсайхан нь: ...“Бизнесийн орчны өмгөөллийн жил” гэж зарлаж байгаа энэ үед нэг чухал байж болох нэг асуудлыг онцолж хэлмээр байна. Өнөөдөр мэргэжлийн холбоод салбар салбараараа төртэй харилцаж байна. Гэвч зөвшөөрлийн шат дамжлага, барилга эхлэх ,үргэлжлүүлэх зөвшөөрөл, зохицуулалтын давхцал зэрэг салбарын хөгжилд чөдөр тушаа болдог олон олон асуудлыг дангаар нь шийдүүлэхэд хүч хүрэхгүй байна.

📌Эдгээр нь нэг салбарын биш — нийт бизнесийн орчны системийн асуудал болсон.

📌Тиймээс танхим мэргэжлийн холбоодын нэгдсэн дуу хоолойг институцчилсэн байдлаар нэгтгэдэг бодит механизм бий болгох шаардлагатай гэж үзэж байна. Танхим дангаараа “санал өгдөг байгууллага” байхаас илүү, салбаруудын нэгдсэн дуу хоолойг институцчилсэн байдлаар нэгтгэдэг платформ болох ёстой. 📌📌Тиймээс 2026 оны төлөвлөгөөнд Танхим–мэргэжлийн холбоодын хамтын ажиллагааны тогтолцоог тодорхой тусгаж, нэгдсэн байр суурьтайгаар төртэй харилцах механизмыг бий болгоё. Учир нь бодлогын түвшинд нөлөөлөх хүч ганц нэгээрээ биш — нэгдэж байж бий болдог. Хэрэв Танхим энэ үүргийг авахгүй бол хэн ч авахгүй гэдэг саналаа илэрхийллээ.

ХОТ, СУУРИН ГАЗРЫГ ДАХИН ХӨГЖҮҮЛЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГЫГ МБҮА ТББ-ЫН ГИШҮҮН БАЙГУУЛЛАГУУДАД ТАНИЛЦУУЛЛАА



2025 оны байдлаар улсын хэмжээнд дахин төлөвлөлтийн 500 гаруй төсөл хэрэгжиж байгаагийн 80 гаруй хувь нийслэл хотод хэрэгжиж байна. Өнгөрсөн 2014-2025 онд нийт 19000 орчим айлын орон сууцны барилга шинээр баригдсан боловч гэр хороолол улам тэлсээр иргэдийн амьдрах орчин, амьдралын чанарт сөргөөр нөлөөлж, эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх

зөрчигдөх, байгалийн гамшигт өртөх, нийгмийн үйлчилгээ хүртэж чадахгүй байх зэрэг тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх шаардлага амьдралд тулгарсаар байна.

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотод 1,677,872 хүн амьдарч байгаа ба хот, суурин дахь ашиглалтын шаардлага хангахгүй хуучирсан барилга байгууламжуудыг буулгаж шинээр барих, гэр хорооллыг барилгажуулах үйл ажиллагааг богино хугацаанд, үр дүнтэй хэрэгжүүлэх асуудлыг нарийвчлан зохицуулах хэрэгтэй болоод байгаа юм.

2026.02.26-ны өдөр МБҮА ТББ-ын дахин төлөвлөлтийн төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа гишүүн байгууллагуудын төлөөллүүдэд Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг ХББОСЯ-ны захиалгаар Хот, Суурин Газрыг Дахин Хөгжүүлэх Тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд зөвлөх үйлчилгээ үзүүлж байгаа “ЭМС консалтинг” ХХК-ийн ахлах хуульч С.Энхжаргал, доктор Б.Батчимэг нар танилцуулж, төсөл хэрэгжүүлэхэд тулгамдаж байгаа асуудлууд болоод цаашид хэрхэн ажиллах, хуулийн үзэл баримтлалд ямар санал тусгуулах талаар санал солилцлоо.

ДАХИН ТӨЛӨВЛӨЛТИЙН ТӨСӨЛ ДЭЭР МБҮА ТББ-ЫН ГИШҮҮН БАЙГУУЛЛАГУУДТАЙ ХАМТРАН АЖИЛЛАНА ГЭДГЭЭ ИЛЭРХИЙЛЛЭЭ

Нийслэлийн зүгээс 2026 оныг бизнес эрхлэгчдийг дэмжих жил болгон зарласан бөгөөд 2026.02.7-ны өдөр Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатар болон холбогдох албаныхан БАРИЛГА, ДЭД БҮТЦИЙН САЛБАРЫН БИЗНЕС ЭРХЛЭГЧИД-тэй уулзаж нийслэлийн бүтээн байгуулалтын төслүүдийг танилцуулахаас гадна салбарын өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаад байгаа зарим асуудлуудыг газар дээр нь шийдвэрлэх, гарц шийдлийг хайх, хамтран ажиллах тал дээр саналаа солилцлоо.

Монголын Барилгын Үндэсний Ассоциаци (МБҮА) ТББ нь барилга, дэд бүтцийн салбарын хөгжлийг тодорхойлоход ихээхэн хувь нэмэр оруулж, томоохон бүтээн байгуулалтуудыг хийсээр ирсэн бөгөөд томоохон бүтээн байгуулагч 200 гаруй компаниудын эрх ашгийг төлөөлдөг мэргэжлийн төрийн бус байгууллага билээ.

Уг арга хэмжээ, уулзалтад МБҮА ТББ нь Удирдах зөвлөлийн гишүүд болоод гишүүн байгууллагуудтайгаа нийслэлийн иргэдийн ая тухтай, аюулгүй, эрүүл амьдрах нөхцлийг бүрдүүлэх, барилгын зах зээлийн багтаамжийг тэлэх чиглэлээр дараах саналуудыг гаргаж албан бичгийн хамт гардуулан өглөө.

📌Архитектур төлөвлөлтийн даалгавар, эскиз батлах, барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох үйл явцыг бүрэн цахимжуулах замаар хүний оролцоог арилгаж, шийдвэр гаргалтыг хурдтай, ил тод болгох – учир нь холбогдох ажлын албадын үйл ажиллагаанд хүнд суртал, техникийн болон хүнээс хамаарсан саатал их байна;



📌Худалдан авах ажиллагаа буюу тендэр зарлах, үнэлэх, хэрэгжүүлэх, хүлээн авах процесс дахь төвлөрлийг арилгах – эдгээр бүх процессыг хот өөрөө төвлөрүүлэн хэрэгжүүлдэг бус сонгон шалгаруулалт, захиалагчын хяналтын үйл ажиллагаанд мэргэжлийн холбоод байгууллагуудыг оролцуулах;

📌Ашиглалтын шаардлага хангахгүй барилга байгууламжийг дахин төлөвлөх ажлыг хувийн хэвшил болон мэргэжлийн ТББ-ууд хариуцан хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх, ашиглалтын шаардлага хангахгүй орон сууцны дахин төлөвлөлтийг ган нэг барилгаар бус орон сууцны хотхон хороороор нь дахин төлөвлөх төслийг хэрэгжүүлж, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, орчны архитектур дизайн-стандартыг алдагдуулахгүй байх өмнөх алдааг давтахгүй байх;

📌Гадаадын зээл, тусламж болон бондын хөрөнгөөр хэрэгжиж байгаа төслүүдэд дотоодын үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийн оролцоог нэмэгдүүлэх, тодорхой шалгуураар хангуулж, дэмжих бодлого баримтлах;

📌Улаанбаатар хот дэлхийн хамгийн хүйтэн нийслэлийн хувьд газар доорх барилга байгууламжуудыг хөгжүүлэх тусгай төсөл хэрэгжүүлэх замаар иргэдийн эрүүл аюулгүй тав тухтай орчинд амьдрах нөхцлийг нэмэгдүүлж, хотын түгжрэл, ачаалал, төвлөрлийг бууруулах - МБҮА ТББ хамтран ажиллахад бэлэн байна;

📌Улаанбаатар хотын суурьшлын томоохон хэсэг болоод буй Богдхан уулын тусгай хамгаалалттай газрын барилгажилтын асуудлыг шийдэрлэж, бодлогоо тодорхойлох;

📌Барилгын инженерийн техникийн нөхцлийг улирал харгалзахгүй (бүтэн жилийн турш) олгодог тогтолцоонд шилжих, техникийн нөхцөл олголтыг цахимжуулах замаар аж ахуйн нэгжүүдийн бизнес төлөвлөлт үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах замаар бүтээн байгуулалтын хурдыг нэмэгдүүлэх;

📌Улаанбаатар хотын эрчим хүчний дутагдал үүсээд буй өнөөгийн нөхцөлд Барилгын архитектур төлөвлөлтийн даалгаварт (А даалгавар) сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр ашиглах техникийн нөхцөлийг тусгах, үйлдвэрлэсэн илүүдэл

эрчим хүчийг төвийн сүлжээнд нийлүүлж ашиг олох тогтолцоо бүрдүүлэх замаар үүсээд буй асуудлыг шийдвэрлэх боломжийг эрэлхийлэх;

📌Барилга бүтээн байгуулалтад ашигладаг том оврын автомашин, механизмыг 22 цагаас хойш хөдөлгөөнд оролцуулахаар заасан байдаг бөгөөд энэ нь хүн амын суурьшлын бүсэд 22 цагаас хойш чанга дуу чимээ гаргахыг хориглодог заалттай зөрчилдөж байгааг эргэн харж оновчтой болгох – учир нь үүнээс үүдэн оршин суугчид, барилгын байгууллагын хооронд зөрчил үүсч, барилгын ажил саатах, гацаах, удаашрах, үргэлжлэх хугацаа уртсах, ханган нийлүүлэгч байгууллагуудыг алдагдалтай ажиллах /байнга торгуулах/ нөхцөл үүсгэдгийг шийдвэрлэх шаардлагатай зэрэг олон асуудлын хүрээнд саналаа хүргүүллээ.

✅Мөн Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатар нь Монголын Барилгын Үндэсний Ассоцаци ТББ-ын гишүүн компаниудтай хамтран ажиллах, ялангуяа дахин төлөвлөлтийн төсөлд нарийвчлан ярилцаж ойлголцолд хүрэх талаар уламжиллаа.

✅Дулаан, цахилгаан, усны асуудал дээр үүсэж буй дэд бүтцийн техникийн нөхцөлүүдийг хэрхэн оновчтойгоор шийдвэрлэх боломж байгааг судалж, салбарт тулгамдаад байгаа гаднаас ажиллах хүч оруулж ирэхэд тулгамдаж байгаа асуудлыг хэрхэн хууль эрх зүйд нийцсэн байдлаар шийдэх, барилгын норм, дүрэм, журмыг хөнгөвчлөх саналыг гаргасан болон барилгын зөвшөөрөл олгох процессыг хялбаршуулж, төр, хувийн хэвшлийн түншлэлээр барилгын компаниудад ашигтай төслийг санал болгохоо илэрхийллээ.

МБУА

ГИШҮҮНЧЛЭЛ, МАРКЕТИНГ

Судалгааны чиглэлээр



ГИШҮҮДЭЭ СОНСЪЁ

2026.01-р сар

МОНГОЛ УЛСЫН МАНЛАЙ УЯАЧ ЦОЛ ТЭМДЭГЭЭР ШАГНУУЛЛАА



МБҮА ТББ-ын Удирдах зөвлөлийн гишүүн, EFES Construction Ерөнхийлөгч, Аж үйлдвэрийн гавьяат С.Мөнхбат танд баяр хүргэж, эрүүл энх, аз жаргал хүсэхийн зэрэгцээ хойч үедээ үлгэр дуурайлал нь байж, амжилт бүтээлийн оргил өөд улам тэмүүлэхийг хүсэн ерөөж, МБҮА ТББ-ын Ерөнхийлөгчдийн зөвлөл, Удирдах зөвлөл болоод гишүүдийн зүгээс халуун талархал илэрхийлье.
МБҮА ТББ

МОНГОЛ ВАНН ХХК-ИЙН ЗАХИРАЛ Ж.МӨНХЦЭЦЭГ ХӨДӨЛМӨРИЙН ГАВЪЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР ШАГНАГДЛАА

2012 онд үүсэн байгуулагдсан МБҮА ТББ-ын Гишүүн байгуулага болох Монгол ванн ХХК-ийн захирал Жадамбаагийн Мөнхцэцэгийг БНСУ-ын технологиор импортыг орлосон шахмал чулуун ванн үйлдвэрлэж дотоодын зах зээлийн 50 хүртэлх хувийг хангасан



үндэсний үйлдвэрийг бий болгож, нийт жижиг дунд үйлдвэрлэгчдийн төлөөлөл болон тууштай ажиллаж явааг үнэлж, Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлигаар “Хөдөлмөрийн гавъяаны улаан тугийн одон”-гоор шагнагдсанд МБҮА ТББ-ын Ерөнхийлөгчдийн зөвлөл, Удирдах зөвлөл болоод гишүүдийн зүгээс халуун талархал илэрхийлье.

МБҮА ТББ-ЫН ГИШҮҮН КОМПАНИУДАД СЭЛБЭ ХОТ ТӨСЛИЙН ОЛОН НИЙТИЙН БҮСИЙН ТАНИЛЦУУЛГЫГ ХИЙЛЭЭ

Сэлбэ 20 минутын хот-ын олон нийтийн бүсэд төсөл хэрэгжүүлэх сонирхолтой хувийн хэвшлийнхэнд нээлттэй сонгон шалгаруулалтыг зарласан бөгөөд тус ажлын хүрээнд МБҮА ТББ нь тус төсөлд хамтран болон дангаар оролцох гишүүн байгууллагууддаа тусгайлсан уулзалтыг 2026.02.09-ны өдөр зохион байгууллаа.
Тус уулзалт арга хэмжээнд “Сэлбэ хорин минутын хот корпорац”-ХХКийн Гүйцэтгэх захирал У.Баатар МБҮА ТББ-ын Гүйцэтгэх захирал М.Энхбаатар болоод тус байгууллагын Удирдах зөвлөлийн гишүүн

байгууллагууд Макс өргөө ХХК, НБИК ХХК, Монкон констракшн ХХК, Заг констракшн ХХК, Ти Энд Жи ХХК, Болд ХХК, Сайхан төмөрт ХХК, Хөх бүрдийн эх ХХК нарын төлөөллийг хүлээн авч тус төслийн инженерийн шугам сүлжээ, дэд бүтцийн талаарх нарийвчилсан мэдээллүүдийг хүргэлээ.

- **ТУС ХОТХОН НЬ**

📌 Нийт талбай: 158 га 98 м өндөр Сэлбэ цамхаг бүхий 1,5км дагуу Сэлбэ голыг дагасан амралтын бүс

🏙️ Төлөвлөсөн орон сууц: 113 блок 8,565

⏰ Хэрэгжих хугацаа: 2025-2028

🚙 🚘 Авто зогсоол: 47,530мкв талбайтай 7 блок

👩‍🏫 🤱 Сургууль: 3780 хүүхдийн 3 сургууль

🚼 Цэцэрлэг: 1200 хүүхдийн 5 цэцэрлэг

🏥 Эмнэлэг: 100 ортой 1 эмнэлэг

🅿️ Худалдаа үйлчилгээний газар : 32

🤼 Спорт цогцолбор: 1

🌳 🌻 🍀 Ногоон байгууламж: 62,6 га талбайн 39,6%-д нь байх юм байна.



СЭЛБЭ 20 МИНУТЫН ХОТ-ЫН ОЛОН НИЙТИЙН БҮСЭД ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ СОНИРХОЛТОЙ ХУВИЙН ХЭВШЛИЙНХЭНД НЭЭЛТТЭЙ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫГ ЗАРЛАЛАА

Сэлбэ 20 минутын хот-ын олон нийтийн бүсэд төсөл хэрэгжүүлэх сонирхолтой хувийн хэвшлийнхэнд нээлттэй сонгон шалгаруулалтыг 2026.01.16-03.02-ны 16:00 цаг хүртэл www.selbecity.mn вэб сайтаар хүлээж авахаар нээлттэй зарлаллаа.

- Сэлбэ хот нь нийт 158 га талбайд хэрэгжих бөгөөд 8575 айлын орон сууц, үйлчилгээ, соёл, бизнесийн цогц орчныг бүрдүүлэх хотын хөгжлийн томоохон бүтээн байгуулалт болох юм.
- Сэлбэ хотын газрыг 2024 онд эрчимтэй чөлөөлж, нийт 113 блок барилгын ажлыг эхлүүлсэн. Эхний ээлжийн орон сууц 2027.05-р сард ашиглалтад орно.
- Төслөөс санал болгож байгаа эхний 15 бүсийн 12 бүс нь олон нийтийн, 3 бүс нь амины сууцаас бүрдэнэ. Олон нийтийн бүс 27.69 га талбай, амины сууцны бүс 15.17 га талбайг хамарна.

СЭЛБЭ ХОТЫН ОРОН СУУЦЖУУЛАХ 3,4-Р БАГЦЫН ТЕНДЕРТ МБҮА ТББ-ЫН ГИШҮҮН МОНКОН КОНСТРАКШН ХХК, НУТГИЙН БУЯН ГРУПП ХХК НАР АЖИЛЛАЖ БАЙНА

Сэлбэ хотын орон сууцжуулах төслийн 3, 4 дүгээр багц тендерт МБҮА ТББ-ын гишүүн компани болох Нутгийн буян групп ХХК, Монкон констракшн ХХК нар шалгарч ажиллаж байгаа байна.

Тухайлбал:

- Багц 3.1 буюу Сэлбэ дэд төвийн 71 айлын есөн давхар бүхий 11 блок орон сууцны иж бүрэн цогцолбор хорооллын тендерт “China Construction Fifth Engineering Bureau” компани,
- Багц 3.2 буюу Сэлбэ дэд төвийн 71 айлын есөн давхар бүхий 12 блок орон сууцны иж бүрэн цогцолбор хорооллын тендерт “Моринсувд” ХХК,
- Багц 3.3 буюу Сэлбэ дэд төвийн 71 айлын есөн давхар бүхий 14 блок орон сууцны иж бүрэн цогцолбор хорооллын тендерт “Нутгийн буян” ХХК,
- Багц 4.1 буюу Сэлбэ дэд төвийн 71 айлын есөн давхар бүхий 16 блок орон сууцны иж бүрэн цогцолбор хорооллын тендерт “Монкон констракшн ХХК ”
- Багц 4.2 буюу Сэлбэ дэд төвийн 71 айлын есөн давхар бүхий зургаан блок болон 71 айлын 12 давхар бүхий найман блок орон сууцны иж бүрэн цогцолбор хорооллын тендерт “Професионалстрой” ХХК шалгарсан юм.

“ТАТВАРЫН ШИНЭЧЛЭЛ – ИРГЭН ТӨВТЭЙ ТАТВАРЫН БОДЛОГО” ХЭЛЭЛЦҮҮЛЭГ БОЛЛОО

МБҮА ТББ нь Татварын хөгжлийн дэвшил холбоо ТББ-тай хамтран “Татварын шинэчлэл – иргэн төвтэй татварын бодлого” уулзалт, хэлэлцүүлгийг 2025.02.05-ны өдөр зохион байгуулагдаж МБҮА ТББ-ын Дэд Ерөнхийлөгч Д.Энхтөр нь шинэ хуулийн төсөд саналаа хамтран өгөх, тусгуулах бодолтой байгаа талаар хэллээ. (Видогоос дэлгэрэнгүй сонсоно уу)

Хэлэлцүүлгээр татварын багц хуулийн шинэчлэлийн чиглэл, хэрэгжилтийн төлөв, мөн татварын орчныг илүү ил тод, шударга, иргэнд ээлтэй болгох бодлогын талаар мэргэжлийн байгууллагуудтай дараах асуудлаар санал солилцлоо.



- Татвар төлөгчийн эрхийг хамгаалах, харилцан итгэлцлийг бэхжүүлэх
- Стандарт, журамд суурилсан татварын үйлчилгээг төлөвшүүлэх
- Татварын боловсролыг нэмэгдүүлж, сайн дурын тайлагналыг дэмжих асуудлаар саналаа солилцож холбогдох албаны хүмүүст хүргэхээр тохирлоо.

“KOREA BUILD 2026” АРГА ХЭМЖЭЭНД МОНГОЛ УЛСЫН БАРИЛГЫН КОМПАНИУДИЙН ТАНИЛЦУУЛГЫГ ХИЙЛЭЭ

Жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг ази тивийн барилгын салбарын хамгийн том үзэсгэлэнгийн нэг болох KOREA BUILD нь архитектур, дотоод засал, барилгын материал, ухаалаг




технологийн салбарын шилдэг шийдлүүдийг танилцуулдаг бөгөөд энэ удаагийн үзэсгэлэн арга хэмжээнд МБҮА ТББ нь Гишүүн байгууллагуудаа танилцуулан сурталчиллаа. БНСУ-ын Илсан хот хотноо 2026.02.04-07-ны хооронд зохион байгуулагдаж буй тус арга хэмжээний үеэр олон улсын зах зээлд нэвтрэх боломж, Солонгосын компаниудтай B2B уулзалтад оролцох, бүтээгдэхүүн, технологио дэлхийд таниулах, сурталчлах, салбарын шинэ чиг хандлага, инновацтай танилцах, экспорт, Монгол Улсад нэвтрүүлэх тал дээр МБҮА ТББ-ын Ерөнхийлөгч Н.Баярсайхан хамтын ажиллагааны шинэ боломжийг судалж холбогдох хүмүүстэй уулзалтуудыг хийлээ.

ГИШҮҮДИЙГ МЭДЭЭ МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАХ ХҮРЭЭНД:

МБҮА ТББ-ын Гишүүнчлэлийнхээ тоог нэмж, үйл ажиллагааныхаа цар хүрээг тэлэх зорилт, 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдан ажлын хүрээнд 2-р сард “Гишүүдээ сонсъё” уриан доор хийгдэх ажлууд ҮРГЭЛЖИЛЖ байна. Үүнд:

- Гишүүнчлэлийн бүтээгдэхүүн үйлчилгээг олон нийтэд таниулан хүргэхээр мэдээлэл постер бэлтгэн холбогдох мэдээ мэдээллийг өгч ажилласны үр дүнд 2026.02-р сард нь барилга угсралт, засал чимэглэл,
-

зураг төслийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Богд асар ХХК болон Их үйлсийн эрэлд ХХК нар гишүүнээр элслээ.



Гишүүн байгууллагуудын захирлуудтай уулзаж санаа бодлын сонсох, уулзалтаас гарсан санал, зөвлөмжийг төлөвлөгөөт ажилдаа тусган ажиллах зорилгоор УУЛЗАЛТЫН ХУВИАР гарган дараах гишүүн байгууллагуудтай уулзан ажиллахыг зэрэгцээ мөн, дараах асуулга, судалгаа, хуудсыг шинэчлэн авах зорилгоор уулзав.
Үүнд:

-Гишүүнчлэлийн бүртгэлийн хуудас
-Сэтгэл ханамжийн судалгаа-2025
-Төрийн дээд одон медаль, цол тэмдгээр шагналаар тодорхойлох хүсэлтийн судалгаа зэрэг багтсан болно.

Гишүүн байгууллагууд:


- Нутгийн буян констракшн ХХК
- Ти Энд Жи ХХК
- Соёолон инженеринг ХХК
- Инвескор Проперти ХХК
- Эрчим Инженеринг ХХК
- Эрин Интернэйшнл ХХК
- Монкон Групп ХХК
- Юни Стийл Констракшн ХХК
- Хьёндэ элеватор монгол ХХК зэрэг болно.

ОЛОН НИЙТ, МАРКЕТИНГИЙН ХҮРЭЭНД:




МБҮА
XVII ЖАРНЫ СҮРЭЭР ДАРАГЧ ХЭМЭЭХ
ГАЛ МОРИН ЖИЛ
САР ШИНЭДЭЭ
САЙХАН ШИНЭЭЛЭЭРЭЙ


МБҮА
МБҮА ТББ-ын тэргүүн дэд ерөнхийлөгч
ЗАГ ГРУПП ХХК-ийн ТҮЗ-ийн Дарга
Б.НЭМЭХБААТАР
Улс улсын төсвийн хөрөнгө оруулалттай бүх ажлынхаа тендерийг өөрсдөө зарладаг, өөрсдөө шалгаруулдаг, өөрсдөө хэрэгжүүлдэг, өөрсдөө хүлээж авдаг. Үүнийгээ эргэж харж зөвлөх үйлчилгээг нэвтрүүлээч гэдэг саналыг тавьж байна.


MNCA
Greeting
Dear Mr.Han Seung-gu, President of the Construction Association of Korea (CAK),
On behalf of the Mongolian National Construction Association (MNCA) NGO and personally, I would like to extend our warmest greetings to you and all your colleagues and members the Construction Association of Korea (CAK) on the joyous occasion of the traditional Lunar New Year of the Republic of Korea - Seollal (설날).
May the New Year bring you good health, abundant success, and great prosperity. May our cooperation continue to strengthen and expand in the years ahead.
Respectfully,


МБҮА
Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч
Х.НЯМБААТАР
МБҮА ТББ-ын Гишүүн компаниудтай бүтээн байгуулалтын төсөлд хамтран ажиллахад бүх талын дэмжлэг үзүүлнэ, барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг бүрэн цахимжуулсан байдал дээр харилцан санал солилцох, туршлага судлах, мэргэшсэн төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллахад нээлттэй байна.


МБҮА
Амар байна уу
Монголын Барилгын Үндэсний Ассоциацын ТББ-ын Гишүүдийн
Уулган сарын цэнгэлт
2026.02 25 10.30 цагт


МБҮА
МБҮА ТББ-ын ҮЗ-ийн гишүүн
Бармон ХХК-ийн захирал
Ш.ҮНЭНБАТ
2014 онд батлагдсан Ерөнхий төлөвлөгөөн дотор Хэсэгчилсэн төлөвлөгөө гэдэг зүйл гаргаад хуулийг уландаа гишгэж байгаа зүйлийг яаралтай таслан зогсоох хэрэгтэй байна. Үр дүнд нь иргэд хохироод байна.


МБҮА
БҮТЭЭН БАЙГУУЛАЛТАД
БЭЛЭН ҮҮ
2-р сар
Огноо: 2026.02.05 08:30-13:00 цагт
"БАРИЛГЫН ТӨСӨВ, ҮНЭ БУРДАЛТ" СУРГАЛТ
Огноо: 2026.02.05 09:00-13:00 цагт
ТАТВАРЫН ХУУЛИЙН ШИНЭЧЛЭЛТЭЙ ХОЛБООТОЙ ТББ-ТАЙ ХИЙХ УУЛЗАЛТ
Огноо: 2026.02.07 10:00 цагт
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА Х.НЯМБААТАР
Огноо: 2026.02.09 11:00 цагт
СЭЛЭЗ ХОТЛОН ТЕНДЕРТ ОРОЛЦОХ ГИШҮҮДИЙН УУЛЗАЛТ
Огноо: 2026.02.25 10:00 цагт
"АМАР БАЙНА УУ-2026" БУЯН ГИШҮҮДИЙН ЗОГСООЛТ
Үйл ажиллагааны төлөвлөгөө



БАРИЛГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ЧИГЛЭЭР



БҮАТЗХ-ИЙН “НЭГ ЦЭГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ”-ИЙН ТОЙМ

Барилгын тухай хуулийн 34.1.14 дэх заалт, Засгийн газрын 2014 оны “Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх тухай” 250 дугаар тогтоол, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын Сайдын 2025 оны “Төрийн зарим чиг гэрээгээр үргэлжлүүлэн гүйцэтгүүлэх тухай” 123 дугаар тушаалын дагуу Тусгай зөвшөөрөлтэй холбоотой зөвөлгөө мэдээллийг “Нэг цэгийн үйлчилгээний төв”-өөр дамжуулан давхардсан тоогоор 800 хуулийн этгээд болон иргэдэд тухай бүр мэдээлэл өгч ажилласан.

Иргэн, хуулийн этгээд болон холбогдох байгууллагаас ирсэн, БҮАТЗХ-с явуулсан бичгийн мэдээ:



БҮАТЗ-тэй холбоотой “Барилга байгууламжийн зураг төслийг боловсруулах, барилгын ажлыг гүйцэтгэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар, үйлчилгээг эрхлэх тусгай зөвшөөрлийг олгох, тэдгээрт хяналтыг тавих, барилгын үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдэд тавих нөхцөл, шаардлагын дагуу барилгын тусгай зөвшөөрлийг license.mn-ээр хүссэн БУ:138, ЗТ:20, ӨБ:4 нийт 162-н хуулийн этгээдийн хүсэлт, материалыг баталгаажуулж, ХБББОСЯ-нд 2026.01.19-ний өдөр албан бичиг болон цахимаар илгээж ХБББОССайдын 2026.01.30-ны өдрийн 15 дугаар тушаалаар баталгаажуулан ирүүлсэн.

Мөн 3 хуулийн этгээдийн оноосон нэр өөрчлөгдсөн тул ХБББОСЯ-нд оноосон нэр өөрчлүүлэх хүсэлт явуулан ХБББОССайдын 2026.01.30-ны өдрийн 14 дүгээр тушаалаар оноосон нэр өөрчлөх тушаал, 1 хуулийн этгээд татан буугдсан тул өөрийн хүсэлтээр тусгай зөвшөөрөл цуцлах хүсэлт ирүүлсний дагуу ХБББОСЯ-нд тусгай зөвшөөрлийн эрхийг цуцлах хүсэлт явуулан ХБББОССайдын 2026.02.02-ны өдрийн 16 дугаар тушаалаар баталгаажуулан холбогдох мэдээлэлд засвар оруулсан.

ХБББОССайдын 2025 оны 124 дүгээр тушаалын дагуу “Зөвшөөрлийн цахим систем”-д шилжих ажлыг зохион байгуулан 2025 оны 09 дүгээр сарын 05-ны өдрөөс эхлэн “LICENSE.MN”-ээр хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэж эхэлсэн.

Тус тайлант хугацаанд license.mn-ээр хүсэлт гаргасан БУ:297, ЗТ:49, ӨБ:8 нийт 353-н хуулийн этгээдийн хүсэлтийг баталгаажуулан ХБББОСЯ-нд холбогдох тушаал гаргуулахаар 2026.02.16-ны өдөр албан бичиг болон цахимаар илгээж ажиллав.

Тайлангийн хугацаанд license.mn-ээр хүсэлт гаргасан хуулийн этгээдийн хүсэлт хянагдаж, 1 удаагийн БАТАЛГААЖУУЛАЛТ-аар 162 хуулийн этгээдийн хүсэлтийг ХБББОССайдын тушаалаар баталгаажуулсан. Дараагийн ээлжинд 353 хуулийн этгээдийн хүсэлтийг баталгаажуулахаар ХБББОСЯ-нд хүргүүлэн ажилласан.

Өнөөдрийн байдлаар БҮАТЗ-н хүсэлт гаргасан хуулийн этгээдийн хүсэлтийн шийдвэрлэлтийн байдал:

Барилга угсралт

- Хянагдахаар хүлээгдэж байгаа 38
- Хянагдаж улсын тэмдэгтийн хураамж төлөхөөр хүлээгдэж байгаа 79
- Хүсэлтийн шаардлага хангуулахаар буцаасан /давхардсан тоогоор/ 111

Зураг төсөл

- Хянагдахаар хүлээгдэж байгаа 5
- Хянагдаж улсын тэмдэгтийн хураамж төлөхөөр хүлээгдэж байгаа 6
- Хүсэлтийн шаардлага хангуулахаар буцаасан /давхардсан тоогоор/ 49

Өргөх байгууламж

- Хянагдахаар хүлээгдэж байгаа 0
- Хянагдаж улсын тэмдэгтийн хураамж төлөхөөр хүлээгдэж байгаа 1
- Хүсэлтийн шаардлага хангуулахаар буцаасан /давхардсан тоогоор/ 6 байна.



Барилга байгууламжийн зураг төслийг боловсруулах, барилгын ажлыг гүйцэтгэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар, үйлчилгээг эрхлэх тусгай зөвшөөрлийг олгох, тэдгээрт хяналтыг тавих, барилгын үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагад тавих нөхцөл, шаардлагын дагуу тусгай зөвшөөрөл авахаар хүсэлт ирүүлсэн 162 хуулийн этгээдийн хүсэлтийн материалыг хянаж 704 инженер, техникийн ажилтнуудын бүртгэлд хяналт тависан бол 162 хуулийн этгээдийн хүсэлтийн материалыг хянаж 1593 инженер, техникийн ажилтнуудын бүртгэлд хяналт тавьж ажиллаа.

- БҮАТЗ-ийг эзэмшигч хуулийн этгээдийн мэдээллийг холбогдох хууль тогтоомж болон ХБББОССайдын 1 удаагийн тушаалын дагуу Улсын бүртгэлийн ерөнхий газрын opendata.burtgel.gov.mn-д БУ: 5721, ЗТ: 1150, ӨБ: 202 хуулийн этгээдийн нийт 7073 мэдээллийг нээлттэй байршуулах хүсэлтийг хүргүүлэв.
- БҮАТЗ-тэй хуулийн этгээдийн мэдээллийг Барилгын нэгдсэн мэдээллийн санд “Холбогдох бичиг баримт хэсэг”-т БУ: 5721, ЗТ: 1150, ӨБ: 202 нийт 7073 хуулийн этгээдийн мэдээллийг үүсгэн www.mcis.gov.mn-ын нээлттэй байршуулав.
- ХБББОССайдын тушаалаар 2025 оны 09 дүгээр сарын 05-ны өдрөөс өмнө цаасан хэлбэрээр олгосон тусгай зөвшөөрөл эзэмшигчийн гэрчилгээг үндэслэн 17 хуулийн этгээдтэй гэрээ байгуулж улсын тэмдэгтийн хураамж 13.300.000 төгрөгийг Чингэлтэй дүүргийн татварын хэлтэст төвлөрүүлэн ажилласан.
- Мөн Зөвшөөрлийн нэгдсэн систем /www.license.mn/-д нийт 375 ААНБ-д улсын тэмдэгтийн хураамжийн төлбөрийн даалгавар үүсгэж, 2026 оны 01 дүгээр сарын 26-ны өдрөөс 02 дугаар сарын 26-ны өдрийг дуустал Барилга угсралтаар 252, зураг төсөл 37, өргөх байгууламж 7, нийт 296 ААНБ-ын баталгаажуулалт хийж, Чингэлтэй дүүргийн татварын хэлтэст улсын тэмдэгтийн хураамж болох 383.450.000 төгрөг төвлөрүүлсэн
- Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олгосон Хот байгуулалтын сайдын 2018 оноос 2025 оны хооронд гаргасан тушаалыг эмхтгэн 11 боть, Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл хүссэн хуулийн этгээдийн 2026 оны 2 дугаар сард баталгаажсан тусгай зөвшөөрөл хүссэн материалын архивын нэгж 25 боть үүсгэсэн.
- Авилгатай тэмцэх газар, Салбарын хяналт шинжилгээ үнэлгээ аудитын газар, Барилга, барилгын материал үйлдвэрлэлийн хэлтэс болон холбогдох газраас шаардлагатай мэдээ мэдээллийг цаг тухайд нь хүргэж ажиллаа.
- Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл эзэмшигч нарт 2025 оны үйл ажиллагааны тайланг ирүүлэх тухай масс мессежийг 6840 хуулийн этгээдэд хүргүүлж мөн Улсын тэмдэгтийн хураамж төлөх тухай масс мессежийг 129-н хуулийн этгээдэд хүргүүлэн ажилласан.



ДУЛААН ШИЙДЭЛ-2





"ДУЛААН ШИЙДЭЛ II" ТӨСЛИЙН БАГИЙН 2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОЙМ

"БАРИЛГЫН ТӨСӨВ, ҮНЭ БҮРДЭЛТ" СУРГАЛТЫГ МБҮА ТББ-ЫНХАА АЖЛЫН АЛБАТАЙ ХАМТРАН ЗОХИОН БАЙГУУЛЛАА





Европын холбооны СВИЧ-Эшиа хөтөлбөрийн санхүүжилттэй, МБҮА ТББ-ын хамтран хэрэгжүүлдэг "Дулаан шийдэл II" төсөл нь Барилгын Төсөвчдийн Холбоо ТББ-тай хамтран “Барилгын төсөв, үнэ бүрдэлт” сургалтыг 2026.02.05-нд зохион байгуулав.


Сургалтыг МБҮА ТББ-ын Гүйцэтгэх захирал М.Энхбаатар нээж: “Энэхүү сургалтыг барилгын салбарын ААНБ, бизнес эрхлэгчдийг чадавхжуулах, тэдгээрийн санал хүсэлт, эрэлт хэрэгцээнд тулгуурлан, барилгын улирлыг угтан зохион байгуулж байгаагаараа онцлог” гэдгийг дурдсан юм. Барилгын Төсөвчдийн Холбооны Тэргүүн Ү.Банди сургалтыг удирдан явуулж, барилгын төсөв гаргахдаа шинжлэх ухааны үндэслэл, тодорхой арга аргачлалд суурилж, үнэн зөв, бодитой тооцоолох нь зүйтэй. Ингэхэд барилгын төсөвчнөөс мэргэжлийн ур чадвар, уйгагүй хөдөлмөр, зөв хандлага, ёс зүйтэй байхыг шаарддаг талаар оролцогчдод зөвлөлөө.

Мөн барилгын төсөв, үнэ бүрдэлтийн чиглэлээр мэргэшиж буй, мэргэшихийг зорьж байгаа инженерүүд нь барилгын ажил гүйцэтгэх технологи, угсралтын стандарт зэргийг зайлшгүй мэдэж байх шаардлагатай. Аливаа барилга байгууламжийн төсвийг зөв тооцоолохын тулд анхнаасаа зурагтайгаа сайтар ажиллах хэрэгтэй. Учир нь тухайн барилгын чанар, ашиглалтад оруулах хугацаа, бүтээмж зэрэг нь төсвөөс шууд хамааралтай байдгийг нэмж мэдээлсэн юм.

ЖЭРЭС ОУТББ-ТАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ ЧИГЛЭЛЭЭ УЛАМ БАТАТГАВ

Жэрэс ОУТББ-ын Суурин төлөөлөгч Завьер Рат, МБҮА ТББ-ын Гүйцэтгэх захирал М.Энхбаатар нар 2026.02.12-нд уулзаж, дараах асуудлуудын хүрээнд хамтран ажиллах чиглэлээ улам бататгасан юм. Уулзалтаар манай талаас МБҮА ТББ нь ойрын саруудад хэрэгжүүлэхээр төлөвлөж буй гол арга хэмжээнүүдээ танилцуулж, цаашид Жэрэс ОУТББ-ын хэрэгжүүлэх төслүүдэд хамтран ажиллах боломжтой гэдгээ илэрхийллээ. Жэрэс ОУТББ-ын талаас "Дулаан шийдэл" төслийн хоёрдугаар үе шатыг амжилттай дуусгах хүрээнд хийгдэх гол ажил, анхаарах асуудлуудын талаар мэдээлэл өгөв.

ТӨСЛИЙН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГУУДЫН УУЛЗАЛТАД ОРОЛЦОЖ, ХИЙСЭН АЖИЛ, ХИЙХЭЭР ТӨЛӨВЛӨЖ БУЙ АЖЛУУДАА ТАНИЛЦУУЛЛАА



2026.02.10-нд болсон ээлжит уулзалтаар Төслийн багийн өмнөх уулзалтаас хойших 14 хоногийн хугацаанд (2026.01.27-02.10) хийсэн ажлуудаа дараах байдлаар танилцуулав. Үүнд,

- 2026.01.29-нд Монголын Ногоон Санхүүгийн Корпораци (МНСК)-аас зохион байгуулсан “Амины орон сууцыг дулаалах, эрчим хүчний хэмнэлттэй шинэ сууц барих, угсармал орон сууцыг шинэчлэхтэй холбоотой экстерналити (дам) зардал, үр ашгийн судалгаа”-ны үр дүн, ашигласан арга зүй, тооцоолол болон дүгнэлтийг хамтран хэлэлцэж, эцсийн тайланг баталгаажуулах уулзалтад төслийн багаа төлөөлж, МБҮА ТББ-ын Гүйцэтгэх захирал М.Энхбаатар оролцож, мэдээлэл авлаа.
- Төслийн багийн Төслийн 4 дүгээр жилийн 3 дугаар улирлын үйл ажиллагааны дэлгэрэнгүй тайланг Жэрэс ОУТББ-аас хүлээн аваад, бидэнд ирүүлсэн асуултад хариулт явуулахаар бэлтгэлээ. Үүнд, 1. Төсөлтэй хамтран ажилладаг барилгын салбарын бизнес эрхлэгчдээс авсан "Санал, хүсэлтийн судалгаа 2025"-ны нэгтгэлийг сайжруулж, дулаалгын зөвлөх тус бүрийн судалгаанд оролцсон анкетыг Англиар орчуулав.
- Оны өмнө Жэрэс ОУТББ-аас Дархан-Уул аймагт зохион байгуулсан иргэд, олон нийтэд зориулсан Нээлттэй өдөрлөгийн үеэр авсан техникийн үнэлгээний гүйцэтгэлийн тайлан (дулаалгын зөвлөхүүдтэй холбоотой)-г эцэслэв.
- Төслийн багаас боловсруулж, МБҮА ТББ-ын Ажлын алба болон төслийн бусад хэрэгжүүлэгч байгууллага руугаа санал авахаар хүргүүлсэн 2026.01-03-р сар дуустал хугацаанд төлөвлөж буй сургалт, арга хэмжээний урьдчилсан хуваарь ёсоор (Та бүхэнтэй өмнө хуваалцсан) 2026.02.05-нд Төслийн баг нь МБҮА ТББ-ын Ажлын алба болон Барилгын төсөвчдийн холбоотой хамтран “Барилгын төсөв, үнэ бүрдэлт” сургалтыг зохион байгууллаа.

Сургалт, арга хэмжээний урьдчилсан хуваарьтай танилцах холбоос:
https://docs.google.com/spreadsheets/d/1UkWpa4xUQCEN26qQeCNE_nOuHuS0WYR7/edit?usp=sharing&ouid=108441573908451803597&rtpof=true&sd=true

Төслийн 4-р жилийн болон 4 жилийн үйл ажиллагааны дэлгэрэнгүй тайланд оруулах нэгтгэлүүдээ гаргаж эхлээд байна. Үүнд,


- Дулаалгын зөвлөхүүдийн Төслийн II үе шат эхэлснээс хойших техникийн үнэлгээ болон дулаалгын ажлын нэгтгэлийг дулаалгын зөвлөх тус бүрээр гаргаж байна.
- Төсөлтэй хамтран ажиллаж буй барилгын салбарын бизнес эрхлэгчдийн тогтвортой байдлыг хангах, бизнесийн холбоо тогтоох зорилгоор зохион байгуулсан арга хэмжээнүүдэд оролцсон оролцогч талуудын жагсаалтыг нэгтгэл байдлаар гаргаж байна.
- Төслийн II үе шатны үйл ажиллагаатай холбоотой 4 жилийн цахим архивыг "Архив, бичиг хэрэг, хөтлөлтийн стандарт"-д нийцүүлэн цаасан архив болгох ажлыг эхлүүлээд байна. Төслийн багт шинээр нэгдсэн ажилтнуудад


- төслийн талаар дэлгэрэнгүй танилцуулж, АБТ-ыг тайлбарлан, удирдлагаар хангаж байна.
- Өнгөрсөн 14 хоногт Дуудлагын төвөөр 10 захиалга ирүүлснийг 7 дулаалгын зөвлөхөд хуваарилсан.

ТӨСӨЛД ХАМРАГДАЖ БУЙ БАРИЛГЫН САЛБАРЫН БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙГ ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ МЭДЭЭЛЭЛ, ЗӨВЛӨМЖӨӨР ТОГТМОЛ ХАНГАВ

https://www.facebook.com/share/p/1DvhoT1KN/

- Төслөөр чадавхжсан дулаалгын зөвлөхүүд, бригадын ахлагчдыг УБ болон Дархан-Уул аймгийн байшинтай өрхүүдэд дулаалгын хэмжилт, үнэлгээ гаргахад нь зориулж, Жэрэс ОУТББ болон Барилгын эрчим хүч хэмнэлтийн төв хамтран боловсруулсан, 2026.02.25-ны байдлаар шинэчлэгдсэн эксел тооцооллыг төсөлтэй идэвхтэй хамтран ажиллаж буй 100 гаруй бригадын бүртгэлтэй мэйл хаягаар





- Төсөлтэй хамтран ажилладаг барилгын салбарын бизнес эрхлэгчдийг чадавхжуулах хүрээнд, тэдгээр бизнес эрхлэгчдийг өөрсдийгөө хөгжүүлэх, ахиж дэвшихэд уриалах үүднээс Эрчим хүчний зохицуулах хороо, ШУТИС-ийн Эрчим хүчний инженерчлэлийн сургууль хамтран зохион байгуулдаг “Эрчим хүч хэмнэлтийн менежер” бэлтгэх ээлжит сургалт 2026.03.16-27-ны хооронд танхим & дадлага ажил гэсэн хэлбэрээр зохион байгуулагдах болсон зарыг албан ёсны эх сурвалжаас нь хүргэлээ.

илгээж & тэдгээрийг нэгтгэсэн “Дулаан шийдэл I-II” төслийн барилгын салбарын бизнес эрхлэгчдийн нэгдсэн фэйсбүүк группт нийтлэв. Ийнхүү Жэрэс ОУТББ-аас шинэчилж ирүүлсэн тус тооцооллын энэ удаагийн гол өөрчлөлт гэвэл Росторг ХХК- ийн 2 төрлийн эрдэст хөвөнгийн үнэд дараах өөрчлөлт оржээ. Үүнд:

- Экоролл TR044 эрдэст хөвөн зузаанаасаа хамааранд 230-920 төг, - Кнауф

TS040 эрдэст хөвөн зузаанаасаа хамааraад 135-540 төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна. - Өөр өөрчлөлт ороогүй болно.

- 2026.03.02-нд Төслийн баг (МБҮА ТББ) нь ШУТИС-ийн дэргэдэх Барилгын эрчим хүч хэмнэлтийн төвтэй хамтран зохион байгуулахаар төлөвлөөд буй “Амины орон сууцны агаар сэлгэлтийн шийдлүүд" онлайн сургалтынхаа зарыг уламжлал ёсоор урьдчилан хүргэлээ. https://www.facebook.com/photo/?fbid=26953926580861535&set=gm.2006776876935931&idorvanity=322577755355860
- Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хороо нь Улаанбаатар хотын тодорхой байршлуудад агаарын бохирдлыг бууруулах цогц төсөл хэрэгжүүлэхийг зорьж байгаа хүрээндээ, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, БНСУ-ын Инчеоны их сургууль зэрэг гадаадын хөрөнгө оруулагч, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах чиглэлээ тохирох цувралаар уулзалт хийж байгаатай холбогдуулан жишээ болгон БНСУ-ын Инчеоны их сургуулийн төлөөлөлтэй хийсэн уулзалтын тухай мэдээллийг албан ёсны эх сурвалжаас нь хуваалцав. Зорилго нь манай төслийн зорилго, зорилттой ижил төстэй төсөл, хөтөлбөр улсын хэмжээнд хэрэгжих боломжтой тодийгүй барилгын эрчим хүч, дулаалгын зах зээл нь улам өргөжин тэлэх ирээдүй байгааг манай төслөөр чадавхажсан барилгын салбарын бизнес эрхлэгчид буюу гүйцэтгэгчид уламжилж, гэрээт ажлуудын тоо, түүнийг дагасан борлуулалт нь нэмэгдэх боломж байгааг хүргэхийг хүссэн юм. https://www.facebook.com/share/p/1HeaggsLu8/
- 2026.02.24-нд Төрийн ордонд зохион байгуулагдсан “Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгээс зохион байгуулж буй цуврал хэлэлцүүлэг”:Уул уурхай, хүнд үйлдвэр; эрчим хүч; байгаль орчин; барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуй; зам тээврийн салбар гэсэн сэдвээр өрнөж, тус хэлэлцүүлгийг gogo.mn мэдээллийн портал сайт шууд дамжуулсныг хуваалцлаа. https://www.facebook.com/share/v/182FEnrDcT/
- Төсөлтэй хамтран ажилладаг ББСБ-ууд нь төслийн татаастайгаар жилийн 6 хувийн, 5 сая хүртэлх төгрөгийн зээл олгож байгаа бөгөөд энэхүү зээл 2026.03.15-н хүртэл сунгагдсан тухай мэдээллийг албан ёсны сурвалжаас нь хуваалцсан нь УБ болон Дархан-Уул аймгийн байшинтай өрхүүдэд төслийн Дуудлагын төвөөр дамжуулж ирсэн техникийн үнэлгээний захиалгыг гүйцэтгэхдээ дулаалгын зөвлөх нь айл өрхүүдэд тус мэдээллийг хүргэснээр борлуулалтад нь нөлөөлөх бодит боломжтой юм. https://www.facebook.com/share/p/1HShqkWRrZ/
- Эрчим хүчний зохицуулах хороо, Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуулийн Эрчим хүчний инженерчлэлийн сургуультай хамтран “Эрчим хүчний аудитор бэлтгэх” ээлжит сургалтаа амжилттай зохион байгуулж, гэрчилгээгээ гардуулсан тухай мэдээллийг төсөлтэй хамтран ажилладаг барилгын салбарын бизнес эрхлэгчид нь эрчим хүчний үр ашиггүй хэрэглээгээ бууруулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэл, ажил, үйлчилгээний бүтээмжээ нэмэгдүүлэх, зардлаа хэмнэх улмаар эдийн засгийн өрсөлдөх чадвараа дээшлүүлэх, өөрийгөө дайчилж, дараагийн шатандаа гараасай гэдэг үүднээс албан ёсны эх сурвалжийн мэдээллийг хүргэлээ. https://www.facebook.com/share/p/1DrQJk3Syd/
- Төслийн хамтран хэрэгжүүлэгчдийн нэг Монголын ногоон санхүүгийн корпорациас Европын холбооны СВИЧ-Эшиа хөтөлбөрийн санхүүжилттэй “Дулаан шийдэл II” төслийн хүрээнд, Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ) болон Монголын ипотекийн корпораци (МИК)-ийн хамтарсан санхүүжилтээр “Орон сууцны салбарт хэрэгжүүлэх эрчим хүчний хэмнэлттэй шийдлүүдийн экстерналити (дам) зардал, үр ашгийг тооцож үнэлсэн цогц судалгаа” хийж,

түүний үр дүнг холбогдох талуудад хүргэсэн тухай мэдээлснийг албан ёсны эх сурвалжаас нь хуваалцлаа. Энэ нь төслийн хүрээнд бодитой, үр дүнтэй, шинэлэг судалгаа хийсэн төдийгүй төслийн үйл ажиллагаагаа цаашид өргөжин тэлэх боломжтой болохыг харуулахыг хүслээ. Энэ нь эргээд манай төсөлтэй хамтран ажиллаж буй барилгын салбарын бизнес эрхлэгчдийн тогтвортой байдлыг хангах хүрээнд мэдээллээр хангаж буй нэг арга, хэлбэр болно.

https://www.facebook.com/share/p/1B33EyxqBZ/

Европын Холбооноос Тайланд улсад Суугаа Төлөөлөгчийн Газар, Европын Холбооноос Монгол Улсад Суугаа Төлөөлөгчийн Газар тэргүүтэй зочид төлөөлөгчид нь төслийн хүрээнд барьж, ашиглалтад оруулж, олон нийтэд танилцуулаад буй “Тэг эрчим хүчний загвар сууц болон төслийн хүрээнд Бодь Пропертийз ХХК-ийн санхүүжилтээр, олон нийтэд нээлттэй зарласан сонгон шалгаруулалтад оролцож, бүтэн дулаалга хийлгэх болзлоо хангасан, төслөөр чадавхжсан бригадуудын дулаалгын ажлыг нь хийж гүйцэтгэсэн 2 айлын нэг болох СХД-ийн 7-р хорооны иргэн У.Насанбатын байшинтай танилцуулсан тухай мэдээг албан ёсны эх сурвалжаас нь хуваалцлаа. Ингэснээр төслийн баг (МБҮА ТББ)-ийн санаачилж, манлайлан хэрэгжүүлсэн байшингийн дулаалгатай цувралаар гадаадын зочид, төлөөлөгчид танилцсаар байгааг мэдээлэх зорилготой байв. Энэхүү газар дээрх айчлалын үеэр иргэн У.Насанбат нь “Дулаалга хийлгэхээс өмнө цан цохих, хөгц үүсэх, ханын цаас хуулрах зэрэг бэрхшээл тулгардаг байсан бөгөөд дулаалга хийлгэсний дараагаар тус асуудлууд ахин гараагүй, хүүхдүүд хөл нүцгэн тоглоход даарахааргүй тухтай болсон бөгөөд ажлаар хөдөө явахад санаа зовох нь багассан тухай онцолсон байна.

https://www.facebook.com/share/p/186B4kteYu/

2026.02.06-нд Төрийн ордонд болсон “Өндөр түвшний хэлэлцүүлэг: “Сэргээгдэх эрчим хүчний нийгэм, эрүүл мэндийн нөлөөлөл, цахилгаан тээврийн хэрэгслийн дэд бүтэц” гэсэн сэдвээр явагдсан бөгөөд тус хэлэлцүүлэгт төслийн хамтран хэрэгжүүлэгч байгууллагуудын нэг болох Монголын ногоон санхүүгийн корпорацийн гүйцэтгэх захирал М.Болд оролцож, байр суурια илэрхийлсэн талаар мэдээллийг албан ёсны эх сурвалжаас нь хүргэлээ. Ингэж хүргэсэн нь төслийн үйл ажиллагаа, түүний зорилго, зорилт нь парламентын түвшинд дотоод & гадаадын олон төлөөлөгчдөд хүргэсээр байгаа бодлого, нөлөөллийн ажлын жишээ гэдгийг уламжлалт ёсоор хүргэсэн нь энэ юм.

https://www.parliament.mn/nn/76663/?fbclid=IwY2xjawQM24teHRuA2FlbQIxMABicmlkETJIQnl3RGdMUHRENVlXUTRDc3J0YwZhcHBfaWQQMjIyMDM5MTc4ODIwMDg5MgABHplJGKn_r6Q56iq4jOEltfrq2q11TEU2f7juLAwW41EFz8oMfZJ77M-KVpnV_aem_Jk_x6HrnK6ZqtPCKs4qoFA

Бодь групп/Бодь Интернэшнл ХХК-аас олон нийтэд зарласан төслийн сонгон шалгаруулалтад МБҮА ТББ нь Дулаан шийдэл II төслийн хүрээнд “Дулаан байшин, тухтай амьдрал” дэд төслийг санаачлан боловсруулж, шалгарсан бөгөөд тус дэд төслийг тус групп/компанийн бүрэлдэхүүнд багтдаг барилгын салбарт үйл ажиллагаагаа явуулдаг Бодь пропертийз ХХК нь санхүүжүүлсэн билээ. Тэгвэл тус комппанийн гүйцэтгэх захирал Б.Тэгшбаяр нь Бодь групп-ийн олон нийтэд зориулан бэлтгэсэн “Бодит Манлайлал” видео контентын анхны дугаарт оролцсон болохыг албан ёсны эх сурвалжаас нь төслийн барилгын салбарын бизнес эрхлэгчдэдээ хуваалцаж, түүний ярилцлагыг сонсоод, төслийн дулаалгын зөвлөх, бригадын ахлагчид хамтран ажиллах боломж эрэлхийлээсэй гэдэг хүссэн болно.

https://www.facebook.com/share/v/1c9mHDt5J7/

Ийнхүү дээрх мэдээлэл, зөвлөмжийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг авах холбоос: https://www.facebook.com/groups/322577755355860

ТӨСӨЛТЭЙ ХАМТРАН АЖИЛЛАЖ БУЙ БАРИЛГЫН САЛБАРЫН БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙН ДУНД “АЖИЛЛАХ ХҮЧНИЙ СУДАЛГАА” ЭХЛҮҮЛЭЭД БАЙНА













“Дулаан шийдэл II” төсөлтэй хамтран ажилладаг барилгын салбарын бизнес эрхлэгчид, дулаалгын зөвлөхүүдтэй хамтын ажиллагаагаа өргөжүүлэх, төслийн бус барилгын бусад төрлийн ажлуудад холбон зуучлах боломжийг эрэлхийлэх, тэдгээрийн нөөц боломж болон санал хүсэлтийг тодорхойлох зорилгоор, одоогоор байдлаар 35 барилгын салбарын бизнес эрхлэгчдээс тандалт судалгаа хийгээд байна.

Судалгааны дүнгээс үзэхэд “Дулаан шийдэл II төсөл”-ийн хүрээнд чадавхажсан барилгын бизнес эрхлэгчдийн 82.9 хувь нь барилгын салбарын мэргэжилтэн байгаа бөгөөд төслийн бус барилгын ажилд оролцох боломжийг судлан үзэхэд 75.8 хувь нь боломжтой гэж хариулжээ. Энэхүү судалгааг цаашид улам өргөжүүлж, барилгын эрчим хүч хэмнэлт, дулаалгын зах зээлийн хүрээнд бүрдсэн чадавх, нөөц, хүчийг цаашид бодлогоор болон бодитоор дэмжих боломж төр, засгийн түвшинд бий эсэхийг эрэлхийлэхийг зорьж байна. Тухайлбал,

Барилгын салбарын ААНБ, бизнес эрхлэгчдийг чадавхжуулах зорилгоор, "Дулаан шийдэл II" төслийн хүрээнд манай ТББ нь бие даан болон бусад хэрэгжүүлэгч байгууллага, өөр бусад оролцогч байгууллагуудтай хамтран зохион байгуулсан 10 хүртэл төрлийн, 2 багц сургалтдаа хамруулж чадавхжуулсан.

Тэдгээр нь барилгын салбартаа идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа төдийгүй төсөлд хамрагдаж байх хугацаандаа барилгын эрчим хүч хэмнэлт, дулаалгын ажлын технологи, арга аргачлал суралцсан, тодорхой гүйцэтгэлтэй Дулаалгын зөвлөх, бригадын ахлагчдыг бэлтгэн гаргалаа.

Цаашид эдгээр барилгын салбарын бизнес эрхлэгчдийн тогтвортой байдлыг хангах зорилгоор ажилд зуучлах, тодорхой чиглэлээр давтан сургах, мэргэшүүлэх, зарим болзол хангасан бригадуудыг мэргэжилтэй боловсон хүчнээр дүйцүүлэх боломжтой эсэх гэх мэт асуудлаар Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам тэргүүтэй төр, засгийн байгууллагад хандахаар төлөвлөж байна.


Өөрөөр хэлбэл, төслийн хүрээнд манай МБҮА ТББ дээр бодит чадавхитай барилгын салбарын бизнес эрхлэгчид байна, барилгын салбарын бизнес эрхлэгчид/хүний нөөцийг чадавхжуулах тодорхой хувь нэмрээ оруулаа, цаашид хэрхэн хамтран ажиллах боломжтой вэ гэх мэт талаар хандвал энэ нь эргээд бодлогын дэмжлэг авах боломжтой болов уу гэж харж байгаа тул энэ чиглэлээр судлаад, тодорхой саналууд бүхий албан бичгийн санал, хавсралтуудаа бэлтгэж байгаа болно. Ийнхүү бүтээлч санал, санаачилга нь барилгын салбарын хөгжил, тэр дундаа энэ салбарт үйл ажиллагаа явуулж буй барилгын салбарын бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаанд чухал түлхэц үзүүлнэ гэж найдаж байна.


ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ХОЛБООТОЙ 4 ЖИЛИЙН ЦАХИМ АРХИВЫГ ТОДОРХОЙ СТАНДАРТАД НИЙЦҮҮЛЭН ЦААСАН АРХИВТ ШИЛЖҮҮЛЭХ АЖИЛ ЭРЧИМТЭЙ ҮРГЭЛЖИЛЖ БАЙНА

байдлаар нэгдсэн, Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх аливаа бүхий л үйл ажиллагааг дэмждэггүй/нэгддэггүй, Европын холбооны стандарт, шаардлагад нийцсэн, МБҮА ТББ нь нийгмийн хариуцлагын хүрээнд хэрэгжүүлж буй төсөл билээ. Тэгвэл уг төслийн үйл ажиллагаатай холбоотой цахим архивыг цаасан хэлбэрээр архивлах нь эргээд байгууллагын дотоод ой санамж, бодлогын залгамжийг хадгалах, цаашид манай дотоод & хамтын ажиллагаагаа улам өргөжин тэлэхэд чухал түлхэц үзүүлэх, дараа дараагийн шатны төслүүдийг хэрэгжүүлэхэд туршлага болох болов уу үзэжэд, энэхүү архив үүсгэх ажлыг эхлүүлээд байна. Ингэхдээ, "Архив, албан хэрэг хөтлөлтийн стандарт"-д нийцүүлэхий зорьж, одоогийн байдлаар дараах хадгаламжийн нэгжийг бүрдүүлээд байгаа юм. Үүнд,

1. “Дулаан шийдэл II төсөл”-ийн Гарын авлага, сургалтын материалууд - 212 хуудас,
2. “Дулаан шийдэл II төсөл”-ийн танилцуулга, мэдээлэл - 218 хуудас,









Европын холбооны СВИЧ-Эшиа хөтөлбөр тэргүүтэй 4 олон улсын санхүүжүүлэгчтэй, "Дулаан шийдэл II" төсөл (2022-2026 он) нь Монгол Улсад хөгжил, хүмүүнлэгийн төсөл статустайгаар, Монгол Улсын Сангийн яаманд албан ёсоор бүртгэлтэйгээр, барилгын эрчим хүч хэмнэлт, дулаалгын зах зээлийг хөгжүүлэх зорилгоор, Жэрэс ОУТББ тэргүүтэй 5 байгууллагын концорсиум

3. Жэрэс ОУТББ болон Монголын Барилгын Үндэсний Ассоциаци ТББ-ын хооронд байгуулсан Түншлэлийн гэрээ буюу хамтран ажиллах Санамж бичиг, түүний нэмэлт өөрчлөлтүүд (2022-2024 он) – 115 хуудас,
4. “Дулаан байшин, тухтай амьдрал” дэд төслийн материалууд-210 хуудас,
5. Дулаан шийдэл II төсөл”-ийн II үе шатны 1, 2, 3 дугаар жилийн үйл ажиллагааны дэлгэрэнгүй англи тайлан (2022-2025) - 192 хуудас,

6. Төслийн I үе шатны хэрэгжүүлэгч байгууллагуудын нэгдсэн тайлан (2018-2022 он) - 28 хуудас,
7. Европын холбооноос төслийн дунд шатны үйл ажиллагаанд хийсэн үнэлгээний тайлан (2024 он) - 63 хуудас,
8. “Дулаан шийдэл I төсөл”-ийн Хаалтын арга хэмжээнд МБҮА ТББ болон хэрэгжүүлэгч байгууллагуудын тавьсан илтгэлүүд (2022 он) - 52 хуудас,
9. Төслийн I, II үе шатны амжилт, сорилт, цаашдын чиг хандлага - 19 хуудас,
10. Европын холбооны ROM үнэлгээний тайлан, санал зөвлөмж (2023 он) - 14 хуудас,
11. Төслийн II үе шатны нээлтэд олон нийтэд тавигдсан мэдээлэл, танилцуулга (2022 он) - 6 хуудас нийт **6 боть хадгаламжийн нэгж бүхий 1129** хуудас материалыг хэвлэн цаасан суурьт шилжүүлээд байна.

2025 ОНЫ 11, 12 ДУГААР САРД ЖЭРЭС ОУТББ-ААС ЗОХИОН БАЙГУУЛСАН МАРКЕТИНГИЙН КАМПАНИТ АЖЛЫН ҮР ДҮНГЭЭ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГУУДДАА ТАНИЛЦУУЛЛАА





Жэрэс ОУТББ-аас удирдан зохион байгуулж, бусад төслийн хэрэгжүүлэгч байгууллагын төлөөллийг багтаасан Төслийн маркетингийн нэгжийн ээлжит уулзалт 2026.02.13-нд боллоо. Уулзалтаар төслийн хүрээнд 2025 оны 11, 12 дугаар сард Улаанбаатар хотноо зохион маркетингийн кампанит ажлынхаа үр дүнг Жэрэс ОУТББ-аас танилцуулсан. Тус байгууллага нь маркетингийн кампанит ажлыг өрнүүлэх Гүйцэтгэгч компанийг уламжлал ёсоор нээлттэй сонгон шалгаруулалт зарласны үндсэн дээр гэрээ байгуулан, хамтран ажилласан байна. Энэ удаагийн маркетингийн кампанит ажлын гол онцлог нь “Хамтач үзэл, хувь нэмэр” гэсэн үзэл санаа/мессежийг олон нийтэд хүргэхийг зорьсон төдийгүй Номин, Миний дэлгүүр, CU гэсэн супермаркетууд болон хүнсний 8 нэрийн барааны дэлгүүр зэрэг 14 байршилд төслийн 5000 гаруй танилцуулгыг байршуулснаараа онцлог болжээ. Мөн түүнчлэн өргөн нэвтрүүлгийн нэр бүхий ТВ-үүд, Чингисийн талбайн чанх эсрэг талд байрлах “Нийслэл дэлгэц”, Prius маркын машинуудад долгион нь таардаг FM радио, Дулаан шийдэл төслийн фэйсбүүк хуудас гэх мэт сувгуудаар сурталчилгааны видео контент цацсан байна. Ингээд энэхүү маркетингийн кампанит ажлаар богино хугацаанд харьцангуй олон иргэдэд барилгын эрчим хүч хэмнэлт, дулаалгын ач холбогдлыг лавшруулан тайлбарлан таниулсан, ББСБ-ын жилийн 6 хүүтэй ногоон зээлийг санал болгож бодит алхамд хөтөлсөн гэх мэт үр дүнтэй байлаа гэж дүгнэж болохоор байна. Энэхүү уулзалтаар төслийн II үе шатыг дуусах хүртэл хугацаанд олон нийтэд чиглэсэн маркетингийн идэвхжүүлэлтээ хийсээр байх, төслийн II шатны хаалтын арга хэмжээг зохион байгуулах хэлбэр, агуулгын талаар талуудаас санал авах зэргээр Маркетингийн нэгжийн үйл явц цааш өрнөнө гэдгийг зохион байгуулагч болох Жэрэс ОУТББ онцлон тэмдэглэлээ.

“ДУЛААН ШИЙДЭЛ II” ТӨСЛИЙН БАГИЙН 2026.02-Р САРЫН ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТОЙМ

Д/д	Үйл ажиллагаа	Тоон үзүүлэлт
1.	Барилгын салбарын БЖДБЭ-дэд зуучилсан техникийн үнэлгээний захиалга	14
2.	Техникийн үнэлгээний захиалгыг хуваарилсан барилгын салбарын БЖДБЭ-ийн тоо	8
3.	Барилгын салбарын БЖДБЭ-ийн хийж гүйцэтгэсэн техникийн үнэлгээний тоо	14
4.	Барилгын салбарын БЖДБЭ-дэд зориулан зохион байгуулсан сургалт, арга хэмжээний тоо	1
5.	Зохион байгуулсан сургалт, арга хэмжээнд оролцсон барилгын салбарын БЖДБЭ-ийн тоо	40
6.	Арга зүйн зөвлөмжийг өгсөн барилгын салбарын БЖДБЭ-ийн тоо	25
7.	Санал, хүсэлт, гомдлыг нь шийдвэрлэсэн айл өрхийн тоо	14



МБҮА
МОНГОЛЫН БАРИЛГЫН ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ
SINCE 2009

Монгол Улс, Улаанбаатар 15141,
Чингэлтэй дүүрэг, 5-р хороо, Самбуугийн гудамж,
МН Тауэр, 8-р давхар, 805, 806, 811 тоот

7011 1515

info@mnca.mn

www.mnca.mn